



**ОРХОН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,  
Урт булаг баг, Ханддоржийн  
гудамж, Утас/Факс: 70359826  
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2023.03.25 № 98  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ОРХОН АЙМГИЙН НИЙГМИЙН  
ДААТГАЛЫН ХЭЛТСИЙН  
ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ Д.НАРМАНДАХ  
ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Орхон аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Орхон аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Улсын төсвөөс 15,703.4 сая төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангаас 10.4 сая төгрөг, нийгмийн даатгалын сангаас 115,024.9 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 79.8 сая төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 0.05 сая төгрөг нийт 130,818.6 сая төгрөгийн орлого төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 140,561.6 сая төгрөг бөгөөд баталсан төсөвтэй харьцуулахад 100.29 хувьтай байна.

“Нийгмийн даатгалын шимтгэлээ өөрөө хариуцан төлсөн зарим даатгуулагчийн шимтгэлийн 50 хувийг буцаан олгох тухай” хуулийн хүрээнд 65,094 иргэнд 2,190.9 сая төгрөгийг буцаан олгожээ.

Байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон ч Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн 1.5-д "САН ХООРОНДЫН АВЛАГА - Сангийн хөрөнгө өөр санд ташаарч

орсон, шаардлагатай үед тухай сангийн мөнгө хэрэлцэхгүй зэрэг шалтгаанаар сан хооронд авлага үүсч болно. Сан хооронд үүссэн авлагыг сангийн орлого ба зардлаар бус сан хоорондын авлагын дансанд бүртгэнэ", 2.4-д "САН ХООРОНДЫН ӨГЛӨГ - Сангийн мөнгөн хөрөнгө өөр санд ташаарч орсон, шаардлагатай үед тухай сангийн мөнгө хүрэлцэхгүй зэрэг шалтгаанаар сан хооронд өглөг үүсч болно, Сан хооронд үүссэн өглөгийг сангийн орлого ба зарлагаар бус сан хоорондын өглөгийн дансанд бүртгэнэ" гэж заасан нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 11.2-д "Хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол нийгмийн даатгалын сангийн хөрөнгийг сан хооронд шилжүүлэн зарцуулах, зориулалтын бус чиглэлээр ашиглах, байршуулахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй байна.

### **Аудитын гол асуудал**

Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2022 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 01/784 дүгээр албан бичгээр арилжааны банк дахь дансны зарлагын гүйлгээг хаах, шүүхэд шилжүүлэх арга хэмжээг тус газраас чиглэл, заавар өгөх хүртэл хугацаанд хойшлуулан, шимтгэлийн авлагатай аж ахуй нэгж, байгууллагатай "Нийгмийн даатгалын шимтгэлийн авлагыг тогтоосон хугацаанд барагдуулахаар тохиролцож байгуулсан гэрээ"-г байгуулан, хэрэгжилтийг хангах, мөн зарлагын гүйлгээг хаасан дансуудыг нээх ажлуудыг зохион байгуулах чиглэл өгсөн байна. Үүний дагуу дагуу авлагыг бууруулах арга хэмжээ зохион байгуулаагүй, тайлант онд авлага 674.4 сая төгрөгөөр өссөн байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 5 зорилтын хүрээнд 54 арга хэмжээг хэрэгжүүлэхээр Нийгмийн даатгалын Ерөнхий газрын даргатай байгуулж, хэрэгжилтийг 92.9 хувьтай гэж үнэлсэн байна.

Тайлант онд байгууллагын ахлах нягтлан бодогч, сангийн нягтлан бодогч болон үйл ажиллагааны нягтлан бодогч нар солигдсон бол 2023 оны 01 дүгээр сард байгууллагын дарга төрийн өөр байгууллагад сэлгэн ажиллах болсон байна.

Тухай аудитыг хийх явцад аудитын дүгнэлт, тайлантай холбогдуулан аудит гүйцэтгэж буй төрийн аудитын албан хаагчид аливаа этгээдийн нөлөөлөл, мэдээллийн нууцлал, ёс зүйтэй холбоотой холбогдох хуулийн дагуу мэдэгдлүүдийг гарган баталгаажуулсан болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**


Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх

үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>25,785,025,688.48</u></b>	<b><u>29,242,373,685.46</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	9,196,348,755.30	13,462,945,513.53
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	9,196,348,755.30	13,462,945,513.53
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	9,196,348,755.30	13,462,945,513.53
31211	Төрийн сангийн харилцах	453,596.99	
31213	Арилжааны банк дахь харилцах	9,195,895,158.31	13,462,935,513.53
31214	Бусад төсөл, нөөцийн харилцах		10,000.00
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	16,550,896,357.18	15,724,276,041.93
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	5,145,355,688.20	5,806,230,776.95
33300	Тагаас, санхүүжилтийн авлага	11,352,332,110.85	9,851,275,288.85
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	53,208,558.13	66,769,976.13
3351	Байгууллагаас авах авлага	53,111,636.13	66,673,054.13
3352	Хувь хүмүүсээс авах авлага	96,922.00	96,922.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	37,780,576.00	55,152,130.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	37,780,576.00	55,152,130.00
35410	Бичиг хэргийн материал	1,349,800.00	135,000.00
35420	Аж ахуйн материал	30,769,500.00	50,869,710.00
35430	Сэлбэг хэрэгсэл	2,878,500.00	3,006,500.00
35470	Бусад хангамжийн материал	2,782,776.00	1,140,920.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>633,457,920.16</u></b>	<b><u>669,907,352.78</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	633,457,920.16	669,907,352.78
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	536,681,809.05	575,844,574.99
39201	Барилга, байгууламж, орон сууц	499,199,022.52	499,199,022.52
39202	Хуримтлагдсан элэгдэл	45,563,723.40	60,716,584.92
39203	Авто-тээврийн хэрэгсэл	12,810,000.00	12,810,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-	2,562,000.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	148,814,794.38	164,999,760.78
39206	Хуримтлагдсан элэгдэл	94,167,267.90	50,251,355.75
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	36,444,404.00	32,757,004.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	20,855,420.55	20,391,271.64
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	96,776,111.11	94,062,777.79
39301	Програм хангамж	9,142,270.00	9,142,270.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	4,846,158.89	7,559,492.21
39303	Бусад биет бус хөрөнгө	92,480,000.00	92,480,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>26,418,483,608.64</u></b>	<b><u>29,912,281,038.24</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>161,984,985.04</u></b>	<b><u>705,806,126.04</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	161,984,985.04	705,806,126.04
<b>413</b>	<b>Өглөг</b>	16,148,400.30	37,005,512.73
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	16,148,400.30	37,005,512.73
<b>414</b>	<b>Урьдчилж орсон орлого</b>	145,836,584.74	668,800,613.31
41410	Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв	145,836,584.74	668,800,613.31
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>26,256,498,623.60</u></b>	<b><u>29,206,474,912.20</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	26,256,498,623.60	29,206,474,912.20

511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	357,106,158.55	357,106,158.55
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>25,825,079,603.61</b>	<b>28,775,055,892.21</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	22,894,498,303.50	25,820,330,608.77
51220	Тайлант үеийн үр дүн	2,930,581,300.11	2,954,725,283.44
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	74,312,861.44	74,312,861.44
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>26,418,483,608.64</u></b>	<b><u>29,912,281,038.24</u></b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>153,020,092,353.37</b>	<b>183,093,135,746.86</b>
<b>11</b>	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>122,616,119,229.59</b>	<b>136,167,207,418.29</b>
<b>112</b>	<b>Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого</b>	122,616,119,229.59	136,167,207,418.29
112001	Тэтгэврийн даатгалын шимтгэл	83,555,571,207.19	90,625,716,904.78
112002	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	8,318,897,973.33	9,609,612,303.89
112003	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	10,860,226,389.75	12,876,878,201.69
112004	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	1,697,189,904.48	1,964,340,082.09
112005	Эрүүл мэндийн даатгалын шимтгэл	18,184,233,754.84	21,090,659,925.84
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>74,872,015.83</b>	<b>124,603,929.57</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	74,872,015.83	124,603,929.57
120002	Хүүгийн орлого	9,317,909.10	
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	58,435,246.73	102,639,687.57
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	37,254,142.73	62,662,749.17
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	410,100.00	54,800.00
1200017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого /Үндсэн хөрөнгө/	20,771,004.00	39,922,138.40
120009	Бусад орлого	7,118,860.00	21,964,242.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>30,329,101,107.95</b>	<b>46,801,324,399.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	-	14,202,386,978.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		14,202,386,978.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	67,275,265.95	60,520,035.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	7,100,000.00	
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	59,890,265.95	59,520,035.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	285,000.00	1,000,000.00
<b>1330</b>	<b>Төсвийн захирагчдаас</b>	29,558,658,342.00	31,855,267,686.00
133002	Төвлөрүүлэх шилжүүлэг	29,558,658,342.00	31,855,267,686.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	703,167,500.00	683,149,700.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	703,167,500.00	672,703,500.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих		10,446,200.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>150,089,511,053.26</b>	<b>180,138,410,463.42</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>150,089,511,053.26</b>	<b>180,138,410,463.42</b>

<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	787,687,562.84	787,973,301.42
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	514,361,772.00	595,967,396.00
210101	Үндсэн цалин	389,702,877.00	400,467,200.00
210102	Нэмэгдэл	90,234,895.00	68,732,760.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	31,544,000.00	45,659,997.00
210104	Урамшуулал	2,880,000.00	81,107,439.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	66,010,407.00	76,126,204.00
210201	Тэтгэврийн даатгал	45,672,600.60	54,829,196.00
210202	Тэтгэмжийн даатгал	5,082,801.34	5,336,577.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,066,241.07	4,269,281.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,016,560.27	1,036,137.00
210205	Эрүүл мэндийн даатгал	10,172,203.72	10,655,013.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	20,370,188.44	17,695,138.80
210301	Гэрэл, цахилгаан	6,201,385.30	6,076,224.34
210302	Түлш, халаалт	7,986,543.14	6,963,863.01
210303	Цэвэр, бохир ус	6,182,260.00	4,655,051.45
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	25,952,015.20	20,488,534.84
210401	Бичиг хэрэг	8,461,200.00	8,140,700.00
210402	Тээвэр, шатахуун	3,240,000.00	2,523,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,967,399.20	6,882,444.84
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	344,000.00	490,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,939,416.00	2,452,390.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	4,000,000.00	2,207,400.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		1,273,100.00
210604	Урсгал засвар	4,000,000.00	934,300.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	192,000.00	475,000.00
210702	Дотоод албан томилолт	192,000.00	475,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	113,066,306.95	28,091,602.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	97,686,354.95	6,422,300.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,200,000.00	9,400,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	359,400.00	589,100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	34,020.00	57,320.00
210807	Газрын төлбөр	693,600.00	693,600.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	7,743,090.00	7,686,220.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	5,349,842.00	3,243,062.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	43,734,873.25	46,922,025.78
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,577,700.00	2,841,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	42,157,173.25	44,081,025.78
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	149,301,823,490.42	179,350,437,162.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	109,267,097,995.00	139,881,058,270.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	109,229,008,704.00	139,873,208,270.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	7,497,091.00	7,850,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	30,592,200.00	

2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	40,034,725,495.42	39,469,378,892.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	40,034,725,495.42	39,469,378,892.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<b>2,930,581,300.11</b>	<b>2,954,725,283.44</b>
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<b>2,930,581,300.11</b>	<b>2,954,725,283.44</b>

### 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	357,106,158.55	74,312,861.44	22,834,190,316.87	23,265,609,336.86
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			60,307,986.64	60,307,986.64
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	357,106,158.55	74,312,861.44	22,894,498,303.51	23,325,917,323.50
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				0.00
C05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0.00
C07	Тайлант үеийн үр дүн			2,930,581,300.10	2,930,581,300.10
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	357,106,158.55	74,312,861.44	25,825,079,603.61	26,256,498,623.60
D01	2022 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	357,106,158.55	74,312,861.44	25,825,079,603.61	26,256,498,623.60
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			-4,748,994.84	-4,748,994.84
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	357,106,158.55	74,312,861.44	25,820,330,608.77	26,251,749,628.76
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				0.00
D08	Тайлант үеийн үр дүн			2,954,725,283.44	2,954,725,283.44
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	357,106,158.55	74,312,861.44	28,775,055,892.21	29,206,474,912.20

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b><u>150,545,874,491.99</u></b>	<b><u>188,261,849,400.10</u></b>
<b>11</b>	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>119,968,910,871.84</b>	<b>136,098,359,475.78</b>
<b>112</b>	<b>Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого</b>	119,968,910,871.84	136,098,359,475.78
112001	Тэтгэврийн даатгалын шимтгэл	82,421,414,678.96	90,584,444,784.74
112002	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	7,606,947,311.06	9,598,912,893.91
112003	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	10,264,189,082.08	12,873,206,432.94
112004	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	1,565,036,959.33	1,968,355,706.10
112005	Эрүүл мэндийн даатгалын шимтгэл	18,111,322,840.41	21,073,439,658.09
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>124,262,854.20</b>	<b>3,923,514,889.32</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	124,262,854.20	3,923,514,889.32
120002	Хүүгийн орлого	9,317,909.10	
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	114,944,945.10	3,923,514,889.32
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	114,534,845.10	3,923,460,089.32
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	410,100.00	54,800.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>30,452,700,765.95</b>	<b>48,239,975,035.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	157,258,000.00	15,703,430,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	157,258,000.00	15,703,430,600.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	67,275,265.95	60,520,035.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдрээ авсан хандив, тусламж	7,100,000.00	
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	59,890,265.95	59,520,035.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	285,000.00	1,000,000.00
<b>1330</b>	<b>Төсвийн захирагчдаас</b>	29,525,000,000.00	31,792,874,700.00
133002	Төвлөрүүлэх шилжүүлэг	29,525,000,000.00	31,792,874,700.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	703,167,500.00	683,149,700.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	703,167,500.00	672,703,500.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих		10,446,200.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b><u>150,496,704,558.77</u></b>	<b><u>183,995,252,641.87</u></b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>150,496,704,558.77</b>	<b>183,995,252,641.87</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>737,721,595.64</b>	<b>739,479,163.64</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	514,361,772.00	595,967,396.00
210101	Үндсэн цалин	392,735,572.00	400,467,200.00
210102	Нэмэгдэл	88,232,600.00	68,732,760.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	30,513,600.00	45,659,997.00
210104	Урамшуулал	2,880,000.00	81,107,439.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	66,000,924.00	76,126,204.00
210201	Тэтгэврийн даатгал	45,666,039.31	54,829,196.00



210202	Тэтгэмжийн даатгал	5,082,071.15	5,336,577.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,065,656.92	4,269,281.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,016,414.23	1,036,137.00
210205	Эрүүл мэндийн даатгал	10,170,742.39	10,655,013.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>20,370,188.44</b>	<b>17,695,138.80</b>
210301	Гэрэл, цахилгаан	6,201,385.30	6,076,224.34
210302	Түлш, халаалт	7,986,543.14	6,963,863.01
210303	Цэвэр, бохир ус	6,182,260.00	4,655,051.45
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>23,089,499.20</b>	<b>19,190,484.84</b>
210401	Бичиг хэрэг	7,789,000.00	6,925,900.00
210402	Тээвэр, шатахуун	3,240,000.00	2,523,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,967,399.20	6,882,444.84
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	344,000.00	490,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,749,100.00	2,369,140.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>4,000,000.00</b>	<b>2,335,400.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл		1,401,100.00
210604	Урсгал засвар	4,000,000.00	934,300.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>192,000.00</b>	<b>475,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	192,000.00	475,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>108,129,512.00</b>	<b>24,848,540.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	97,686,354.95	6,422,300.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,200,000.00	9,400,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	359,400.00	589,100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	34,020.00	57,320.00
210807	Газрын төлбөр	693,600.00	693,600.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	7,743,090.00	7,686,220.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	413,047.05	
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>1,577,700.00</b>	<b>2,841,000.00</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,577,700.00	2,841,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>149,758,982,963.13</b>	<b>183,255,773,478.23</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>109,724,387,197.71</b>	<b>143,786,394,586.23</b>
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	109,669,776,415.55	139,874,811,691.80
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	7,497,091.00	7,850,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	16,521,491.16	3,903,732,894.43
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	30,592,200.00	
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>40,034,595,765.42</b>	<b>39,469,378,892.00</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	40,034,595,765.42	39,469,378,892.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)-(1)-(2)</b>	<b><u>49,169,933.22</u></b>	<b><u>4,266,596,758.23</u></b>

7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)		4,266,596,758.23
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	9,147,178,822.08	9,196,348,755.30
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	9,196,348,755.30	13,462,945,513.53

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Гүйцэтгэлийн хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	140,150,357,200.00	140,561,620,820.44	(411,263,620.44)	100.29
21	УРСГАЛ ЗАРДАЛ	140,150,357,200.00	140,561,620,820.44	(411,263,620.44)	100.29
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	684,564,800.00	678,959,128.64	5,605,671.36	99.18
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	544,794,700.00	543,734,962.00	1,059,738.00	99.81
210101	Үндсэн цалин	400,467,200.00	400,467,200.00	-	100.00
210102	Нэмэгдэл	68,752,500.00	68,732,760.00	19,740.00	99.97
210103	Унаа хоолны хөнгөлөлт	46,270,400.00	45,659,997.00	610,403.00	98.68
210104	Урамшуулал	29,304,600.00	28,875,005.00	429,595.00	98.53
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	70,521,700.00	68,838,603.00	1,683,097.00	97.61
210201	Тэтгэврийн даатгал	49,128,400.00	47,541,595.00	1,586,805.00	96.77
210202	Тэтгэмжийн даатгал	5,348,300.00	5,336,577.00	11,723.00	99.78
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,278,700.00	4,269,281.00	9,419.00	99.78
210204	Ажилгүйдлийн даатгал	1,069,700.00	1,036,137.00	33,563.00	96.86
210205	Эрүүл мэндийн даатгал	10,696,600.00	10,655,013.00	41,587.00	99.61
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	17,980,400.00	17,695,138.80	285,261.20	98.41
210301	Гэрэл, цахилгаан	6,299,100.00	6,076,224.34	222,875.66	96.46
210302	Түлш, халаалт	6,996,000.00	6,963,863.01	32,136.99	99.54
210303	Цэвэр, бохир ус	4,685,300.00	4,655,051.45	30,248.55	99.35
2104	Хангамж, бараа материалын зардал	18,484,800.00	18,190,484.84	294,315.16	98.41
210401	Бичиг хэрэг	6,937,400.00	6,925,900.00	11,500.00	99.83
210402	Тээвэр, шатахуун	1,529,100.00	1,523,000.00	6,100.00	99.60
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,883,300.00	6,882,444.84	855.16	99.99
210405	Хог хаягдал зайлуулах, хортон	760,000.00	490,000.00	270,000.00	64.47

	мэрэгчдийн устгал, ариутгал				
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,375,000.00	2,369,140.00	5,860.00	99.75
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	2,355,400.00	2,335,400.00	20,000.00	99.15
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,405,400.00	1,401,100.00	4,300.00	99.69
210604	Урсгал засвар	950,000.00	934,300.00	15,700.00	98.35
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	475,000.00	475,000.00	-	100.00
210702	Дотоод албан томилолт	475,000.00	475,000.00	-	100.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	27,102,800.00	24,848,540.00	2,254,260.00	91.68
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,457,700.00	6,422,300.00	35,400.00	99.45
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	9,400,000.00	9,400,000.00	-	100.00
210803	Даатгалын үйлчилгээ	600,000.00	589,100.00	10,900.00	98.18
210804	Тээврийн хэрэгслийн татвар	100,000.00	57,320.00	42,680.00	57.32
210807	Газрын төлбөр	700,000.00	693,600.00	6,400.00	99.09
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	9,845,100.00	7,686,220.00	2,158,880.00	78.07
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	2,850,000.00	2,841,000.00	9,000.00	99.68
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,850,000.00	2,841,000.00	9,000.00	99.68
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	139,465,792,400.00	139,882,661,691.80	(416,869,291.80)	100.30
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	139,465,792,400.00	139,882,661,691.80	(416,869,291.80)	100.30
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	139,457,932,400.00	139,874,811,691.80	(416,879,291.80)	100.30
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	7,860,000.00	7,850,000.00	10,000.00	99.87
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	140,150,357,200.00	130,818,606,807.72	9,331,750,392.28	93.34
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	15,703,430,600.00	15,703,430,600.00	-	100.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	15,703,430,600.00	15,703,430,600.00	-	100.00
<b>1340</b>	<b>НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	124,446,926,600.00	115,035,366,017.70	9,411,560,582.30	92.44
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	124,436,480,400.00	115,024,919,817.70	9,411,560,582.30	92.44

134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	10,446,200.00	10,446,200.00	-	100.00
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	-	79,810,190.02	(79,810,190.02)	
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		79,755,390.02	(79,755,390.02)	
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		54,800.00	(54,800.00)	
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		9,196,338,570.24	(9,196,338,570.24)	
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		13,462,935,513.53	(13,462,935,513.53)	
<b>6</b>	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>			-	
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	1.00	1.00	-	100.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	-	100.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	38.00	39.00	(1.00)	102.63
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	31.00	33.00	(2.00)	106.45
620003	Үйлчлэх ажилтан	6.00	5.00	1.00	83.33
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>38.00</b>	<b>39.00</b>	(1.00)	102.63
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	32.00	26.00	6.00	81.25
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	6.00	13.00	(7.00)	216.67

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>75,166,390.95</b>	<b>60,520,035.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>75,166,390.95</b>	<b>60,520,035.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	75,166,390.95	60,520,035.00
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>		52,232,434.00
210104	Урамшуулал		52,232,434.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>		7,287,601.00
210201	Тэтгэврийн даатгал		7,287,601.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	6,187,834.00	1,000,000.00
210401	Бичиг хэрэг	690,000.00	
210402	Тээвэр, шатахуун	1,500,000.00	1,000,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	330,000.00	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,667,834.00	
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	500,000.00	-

210604	Урсгал засвар	500,000.00	
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	428,000.00	-
210702	Дотоод албан томилолт	428,000.00	
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	63,598,390.95	-
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	63,598,390.95	
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	4,452,000.00	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,452,000.00	
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>166.00</b>	-
213503	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	166.00	
225001	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	1,050,000.00	
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	76,216,390.95	60,520,035.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	76,216,390.95	60,520,035.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	8,350,000.00	
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	64,198,390.95	59,520,035.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,668,000.00	1,000,000.00

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Нийгмийн даатгалын хэлтэс нь нийгмийн даатгалын үйлчилгээг иргэдэд хүргэх үйл ажиллагаа явуулдаг, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны харьяа байгууллага юм.

Нийгмийн даатгалын хэлтсийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Бид даатгуулагчийнхаа итгэл найдвар, сэтгэл ханамжаар үнэлэгдэх нийгмийн даатгалын үйлчилгээг хүргэх” гэж тодорхойлсон байна.

Дээрх зорилгыг хэрэгжүүлэхийн тулд тайлант онд “Эрх зүй, мэдээллийн технологийн шинэчлэл /80 жил/” гэсэн зорилтыг дэвшүүлэх ажиллажээ.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус байгууллага нь тайлант онд санхүү нягтлан бодох бүртгэлдээ дараах хууль тогтоомж, дүрэм журмыг мөрдөж ажилласан байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль,
- Хөдөлмөрийн тухай хууль,
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль,
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль,
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль,
- Нийгмийн даатгалын багц хуулиуд
- Татварын ерөнхий хууль,
- Нийгмийн даатгалын шимтгэлээ өөрөө хариуцан төлсөн зарим даатгуулагчийн шимтгэлийн 50 хувийг буцаан олгох тухай хууль,
- Төрийн хэмнэлтийн тухай хууль,

- Засгийн газрын 382 дугаар тогтоол,
- Загийн газрын 91 дүгээр тогтоол
- Сангийн сайдын 388 дугаар тушаал,
- Сангийн сайдын 341 дүгээр тушаал

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлогод дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хуульд 6 удаагийн нэмэлт өөрчлөлт,
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд 1 нэмэлт өөрчлөлт,
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд 1 нэмэлт,
- Төрийн хэмнэлтийн тухай хууль,
- Хөдөлмөрийн тухай хууль,
- Сангийн сайдын 2022 оны 120 дугаар тушаал “Албан томилолтын зардлын тариф шинэчлэн тогтох тухай”,
- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/191 дугаар тушаал “Ээлжийн амралт олгох, ээлжийн амралтын цалин тооцох журам”,
- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/192 дугаар тушаал “Дундаж цалин хөлс тодорхойлох журам”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт нь сангийн үйл ажиллагаанд үр нөлөөтэй хэрэгжсэн байна.

Харин хэлтсийн үйл ажиллагааны санхүүжилт, зарцуулалтад хяналт хэрэгжүүлэхээр төлөвлөөгүй байна.

Хяналт шалгалт дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Нийгмийн даатгалын хэлтсийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2022 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн А/65 дугаар тушаалаар баталсан “Нийгмийн даатгалын сангийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-г мөрдөн ажиллаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон ч Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн 1.5-д "САН ХООРОНДЫН АВЛАГА- Сангийн хөрөнгө өөр санд ташаарч орсон, шаардлагатай үед тухай сангийн мөнгө хэрэлцэхгүй зэрэг шалтгаанаар сан хооронд авлага үүсч болно. Сан хооронд үүссэн авлагыг сангийн орлого ба зардлаар бус сан хоорондын авлагын дансанд бүртгэнэ", 2.4-д "САН ХООРОНДЫН ӨГЛӨГ- Сангийн мөнгөн хөрөнгө өөр санд ташаарч орсон, шаардлагатай үед тухай сангийн мөнгө хүрэлцэхгүй зэрэг шалтгаанаар сан хооронд өглөг үүсч болно, Сан хооронд үүссэн өглөгийг сангийн орлого ба зарлагаар бус сан хоорондын өглөгийн дансанд бүртгэнэ" гэж заасан нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 11.2-д "Хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол нийгмийн даатгалын сангийн хөрөнгийг сан хооронд шилжүүлэн зарцуулах, зориулалтын бус чиглэлээр ашиглах, байршуулахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Нийгмийн даатгалын хэлтсийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан "Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 3,493.8 сая төгрөгөөр буюу 13.2 хувиар өссөн байна.

#### Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/сая төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	9,196.3	13,462.9	4,266.6
Авлага	16,550.9	15,724.3	(826.6)
Бараа материал	37.8	55.2	17.4
Үндсэн хөрөнгө	633.5	669.9	36.4
<b>Нийт хөрөнгө</b>	<b>26,418.5</b>	<b>29,912.3</b>	<b>3,493.8</b>
Өр төлбөр	162.0	705.8	543.8
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	26,256.5	29,206.5	2,950.0
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>26,418.5</b>	<b>29,912.3</b>	<b>3,493.8</b>

Дээрх хүснэгтээс харахад мөнгөн хөрөнгө өмнөх оноос 4,266.6 сая төгрөгөөр өссөн нь 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийн тэтгэвэр тэтгэмжийн олгох мөнгөн хөрөнгийг харилцах дансандаа үлдээснээс шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө өмнөх оноос 36.4 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд 80.5 сая төгрөгийн хөрөнгө нэмэгдсэнтэй холбоотой байна.

Бараа материалын данс өмнөх оноос 17.4 сая төгрөгөөр өссөн нь 20.2 сая төгрөгийн аж ахуйн материал үнэ төлбөргүй хүлээн авсантай холбоотой байна.

### 3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 13,462.9 сая төгрөг болж, өмнөх оноос 4,266.6 сая төгрөгөөр өссөн байна.

#### Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Кассад байгаа бэлэн мөнгө	-	-	
Банканд байгаа бэлэн мөнгө	9,196.3	13,462.9	4,266.6
Төгрөг	9,196.3	13,462.9	4,266.6
Төрийн сангийн харилцах	0.4	-	(0.4)
Арилжааны банк дахь харилцах	9,195.9	13,462.9	4,267.0
Гадаад валют	-	-	
Арилжааны банк дахь харилцах	-	-	
Замд яваа мөнгөн хөрөнгө	-	-	
<b>Дүн</b>	<b>9,196.3</b>	<b>13,462.9</b>	<b>4,266.6</b>

Эх сурвалж: Нийгмийн даатгалын хэлтсийн 2022 оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 13,462.9 сая төгрөг нь арилжааны 5 банканд 17 дансанд байршиж байна. Өмнөх оноос мөнгөн хөрөнгө 4,266.6 сая төгрөгөөр өссөн нь 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийн тэтгэвэр тэтгэмжийн олгох мөнгөн хөрөнгийг харилцах дансандаа үлдээснээс шалтгаалжээ.

### 3.5.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 15,724.3 сая төгрөг болж, өмнөх оноос 826.6 сая төгрөгөөр буурсан байна.

#### Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчтай холбогдсон авлага	-	-	-
Төлбөртэй үйлчилгээний авлага	5,145.4	5,806.2	660.8
Татаас, санхүүжилтийн авлага	11,352.3	9,851.3	(1,501.0)
Дансны авлага /ТӨҮГ/	-	-	-
Татвар, НДШ-ийн авлага /ТӨҮГ/	-	-	-
Татаас, санхүүжилтийн авлага	-	-	-
Байгууллагаас авах авлага	53.1	66.7	13.6
Хувь хүмүүсээс авах авлага	-	-	-
<b>Дүн</b>	<b>16,550.8</b>	<b>15,724.3</b>	<b>(826.6)</b>

Эх сурвалж: Нийгмийн даатгалын хэлтсийн 2022 оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн тайлан

Тайлант онд төлбөртэй үйлчилгээний авлага болон байгууллагаас авах авлага нийт 674.4 сая төгрөгөөр өсжээ. Энэ нь Ковид 19 цар тахлаас шалтгаалан, ААН-үүдэд шимтгэлийн хүндрэл учруулахгүй гэсэн НДЕГ-аас өгсөн чиглэлийн дагуу ААН-ийн шимтгэлийн төлөлтийн авлага өссөнөөс шалтгаалжээ.

Харин татаас санхүүжилтийн авлага өмнөх оноос 1,501.0 сая төгрөгөөр буурсан байна.



### Аудитын илрүүлэлт:

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, насжилт ихтэй авлагыг бүрэн барагдуулах талаар үр дүнтэй арга хэмжээ авч ажиллаагүй байна. Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 24.1-д “Нийгмийн даатгалын байгууллага дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ”, 24.1.1-д “нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн биелэлтийг зохион байгуулах”, 24.1.2-д “нийгмийн даатгалын санг бүрдүүлж, орлого, зарлагын гүйцэтгэлийг хангах” гэж заасантай нийцэхгүй, Эрүүл мэнд, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2017 оны А/108 дугаар тушаалаар баталсан “Нийгмийн даатгалын шимтгэлийн авлагыг үүссэн хугацаагаар нь ангилах, хянан шийдвэрлэх журам”-г хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

### **3.5.3 Урьдчилгаа**

Тайлант онд урьдчилж гарсан зардал байхгүй байна.

#### *Хүснэгт 4. Урьдчилгаа дансны үлдэгдэл*

Үзүүлэлт	<i>/сая төгрөгөөр/</i>		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Урьдчилж гарсан зардал	-	-	
Урьдчилгаа тооцоо	-	-	
Бараа материал бэлтгэх урьдчилгаа	-	-	-
Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа	-	-	
Дүн	-	-	-

Эх сурвалж: Нийгмийн даатгалын хэлтсийн 2022 оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн тайлан

### **3.5.4 Бараа материал**

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 55.2 сая төгрөг болж, өмнөх оноос 17.4 сая төгрөгөөр өссөн байна.

#### *Хүснэгт 5. Бараа материалын үлдэгдэл*

Үзүүлэлт	<i>/сая төгрөгөөр/</i>		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
<b>Түүхий эд материал</b>	-	-	
Тусгай зориулалттай материал	-	-	
Эм боох материал			
<b>Дуусаагүй үйлдвэрлэл</b>	-	-	
<b>Бэлэн бүтээгдэхүүн</b>	-	-	
<b>Хангамжийн материал</b>	<b>37.8</b>	<b>55.1</b>	<b>17.4</b>
Бичиг хэргийн материал	1.3	0.1	(1.2)
Аж ахуйн материал	30.8	50.9	20.1
Сэлбэг хэрэгсэл	2.9	3.0	0.1
Түлш, шатах тослох материал	-	-	
Барилгын засварын материал	-	-	
Хүнсний материал	-	-	
Бусад хангамжийн материал	2.8	1.1	(1.7)
<b>Мал амьтад</b>	-		
<b>Дүн</b>	<b>37.8</b>	<b>55.1</b>	<b>17.4</b>

Эх сурвалж: Нийгмийн даатгалын хэлтсийн 2022 оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн тайлан

Тайлант онд бараа материал өмнөх оноос 17.4 сая төгрөгөөр өссөн нь аж ахуйн 20.1 сая төгрөгийн материал хүлээн авсантай холбоотой байна.

#### Аудитын илрүүлэлт

- Бараа материалын орлогын баримт хөтөлдөггүй, шаардах хуудас дугаарладаггүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.5-д "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна", Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар баталсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар"-н 3.2-д "Орлогын баримт НХМаягт БМ-2Бэлтгэн нийлүүлэгч байгууллагаас ирсэн болон өөрийн үйлдвэрийн цех, тасаг, туслах аж ахуйгаас боловсруулсан зүйл, үйлдвэрт тавьж олгосон төрөл бүрийн материалын зарцуулагдаагүй үлдэгдэл, үйлдвэрлэлийн гологдлоос гарсан өөдөс хаягдал, үндсэн хөрөнгийн устгалтаас ашигласан материал, үнэ бүхий зүйлийг орлого болгоход эд хариуцагч нар дагалдан ирсэн бичиг баримтыг үндэслэн орлогын баримтыг 2 хувь бичиж, 1 хувийг өөртөө авч агуулахын бүртгэлд бичилт хийсний дараа тайлангийн хугацаанд санхүүгийн албанд, үлдэх хувийг тээвэрлэгч болон материалыг тушаагчид өгнө" гэж заасантай нийцэхгүй, аудитын иж бүрэн байх батламж мэдэгдлийн хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Бараа материалын орлогын баримт хөтөлж, шаардах хуудсыг дугаарлаж, анхан шатны баримтын бүрдлийг хангаж ажиллахыг зөвлөж байна.

#### **3.5.5 Бусад эргэлтийн хөрөнгө**

Бусад эргэлтийн хөрөнгө бүртгэлгүй байна.

#### **3.5.6 Үндсэн хөрөнгө**

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 669.9 сая төгрөг болж, өмнөх оноос 36.4 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт 7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/
			Өсөлт (+), Бууралт (-)
<b>Биет хөрөнгө</b>			
Барилга, байгууламж, орон сууц	453.6	438.5	(15.1)
Авто-тээврийн хэрэгсэл	12.8	10.2	(2.6)
Машин тоног төхөөрөмж(компьютер)	54.6	114.7	60.1
Тавилга, аж ахуйн эд хогшил	15.6	12.4	(3.2)
Бусад үндсэн хөрөнгө			
Дуусаагүй барилга, байгууламж			
<b>Биет бус хөрөнгө</b>			
Программ хангамж	4.3	1.6	(2.7)
Бусад биет бус хөрөнгө	92.5	92.5	-

<b>Бусад хөрөнгө /ТӨҮГ/</b>			
Хойшлогдсон татварын хөрөнгө /ТӨҮГ/			
Бусад эргэлтийн бус хөрөнгө /ТӨҮГ/ + Бусад			
<b>Дүн</b>	<b>633.5</b>	<b>669.9</b>	<b>36.4</b>

Эх сурвалж: Нийгмийн даатгалын хэлтсийн 2022 оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн тайлан

Тайлант онд үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл өмнөх оноос 36.4 сая төгрөгөөр өссөн нь 80.5 сая төгрөгийн машин тоног төхөөрөмж үнэ төлбөргүй хүлээн авсантай холбоотой байна.

### 3.5.7 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэл 705.8 сая төгрөг болж, өмнөх оноос 543.8 сая төгрөгөөр өссөн байна.

#### Хүснэгт 8. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/ сая төгрөгөөр/
			Өсөлт (+), Бууралт (-)
Бараа үйлчилгээний зардлын өглөг	16.1	37.0	20.9
Урьдчилж орсон орлого	145.9	668.8	523.0
<b>Дүн</b>	<b>162.0</b>	<b>705.8</b>	<b>543.8</b>

Эх сурвалж: Нийгмийн даатгалын хэлтсийн 2022 оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн тайлан

Тайлант онд нийт өр төлбөр 543.8 сая төгрөгөөр өссөн нь урьдчилж орсон орлого нэмэгдсэнтэй холбоотой байна.

### 3.5.10 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 29,206.5 сая төгрөг болж, өмнөх оноос 2,950.0 сая төгрөгөөр өссөн байна.

#### Хүснэгт 9. Засгийн газрын хувь оролцоо

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/ сая төгрөгөөр/
			Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	357.1	357.1	-
Өмч /төрийн/ /ТӨҮГ/			
Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/			
<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>25,825.1</b>	<b>28,775.1</b>	<b>2,950.0</b>
Өмнөх үеийн үр дүн	22,894.5	25,820.3	2,925.8
Тайлант үеийн үр дүн	2,930.6	2,954.7	24.1
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	74.3	74.3	-
<b>Дүн</b>	<b>26,256.5</b>	<b>29,206.5</b>	<b>2,950.0</b>

Эх сурвалж: Нийгмийн даатгалын хэлтсийн 2022 оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн тайлан

Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл дансны үлдэгдэл 74.3 сая төгрөгт өөрчлөлт ороогүй байна.

Хуримтлагдсан үр дүн 28,775.1 сая төгрөг болж 2,950.0 сая төгрөгөөр өссөн нь тайлант оны үр дүн 2,954.7 сая төгрөг, нягтлан бодох бүртгэлийн өөрчлөлт (4.7) сая төгрөг бүртгэснээс шалтгаалжээ.

Бодлогын өөрчлөлт алдааны залруулга дансанд өмнөх оны актын орлого 4.6 сая төгрөг, илүү төлсөн шимтгэлийн буцаалт 0.2 сая төгрөг, буцаасан шимтгэлийн авлага 0.04 сая төгрөгийн зөрүүгээр (4.7) сая төгрөгийн залруулга байна.

### **3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Тус төвлөрүүлэн захирагчийн 2022 оны төсвийн төсөлд сангийн орлогыг 87,220.8 сая төгрөг, нийт зарлагыг 134,115.8 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, байгууллагын урсгал зардалд 943.2 сая төгрөг, санхүүжүүлэх эх үүсвэрийг 943.2 сая төгрөгөөр тооцон дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс сангийн орлогыг 29,039.8 сая төгрөгөөр нэмэгдүүлж 116,260.6 сая төгрөгөөр, сангийн зардлыг 16,584.5 сая төгрөгөөр бууруулж 117,531.3 сая төгрөгөөр, байгууллагын үйл ажиллагааны урсгал зардлыг 272.6 сая төгрөгөөр бууруулж, 670.6 сая төгрөгөөр Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2021 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 23 дугаар тогтоолоор баталсан байна. Энэ нь сангийн болон үйл ажиллагааны урсгал зардлын төсвийн төслийг бодитой, үндэслэлтэй боловсруулаагүйгээс шалтгаалсан байна.

#### **3.5.2 Төсвийн гүйцэтгэл**

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 8 хөтөлбөрийг санхүүжүүлэхээр 15,703.4 сая төгрөгийг улсын төсвөөс, 116,276.9 сая төгрөгийг нийгмийн даатгалын сангаас, 10.4 сая төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэхээр баталсан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 15,703.4 сая төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангаас 10.4 сая төгрөг, нийгмийн даатгалын сангаас 115,024.9 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 79.8 сая төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 0.05 сая төгрөгийн орлого төвлөрүүлсэн байна.

Үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогыг төлөвлөөгүй ч гүйцэтгэлээр үндсэн үйл ажиллагааны орлого 79.8 сая төгрөг, туслах үйл ажиллагааны орлого 0.05 сая төгрөгийг бүрдүүлсэн.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2022 оны 03 дугаар сарын 14-ны өдрийн А/42, 2022 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн А/96 дугаар тушаал, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 05 дугаар тогтоолоор тодотгол орж сангийн орлогыг 116,276.9 сая, зарлагыг 140,150.4 сая төгрөгөөр, үйл ажиллагааны урсгал зардлыг 683.1 сая төгрөгөөр төсөвт тодотгол хийсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 140,561.6 сая төгрөг буюу 100.29 хувьтай байгаа нь өндөр настны тэтгэвэр 2 хувиар, ажилгүйдлийн тэтгэмж 16 хувиар, жирэмсний болон амаржсаны тэтгэмж 2 хувиар давуулан зарцуулсантай холбоотой байна.

Байгууллагын урсгал зардлын төсвийн зардлын гүйцэтгэл 679.7 сая төгрөг буюу 99.5 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг 1.0 сая төгрөг, нийгмийн даатгалд төлөх шимтгэлийг 1.7 сая төгрөг, байр ашиглалттай

холбоотой тогтмол зардлыг 0.3 сая төгрөгөөр, хангамж бараа материалын зардлыг 0.3 сая төгрөгөөр тус тус хэмнэж, 3.4 сая төгрөгийг буцаан төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

*Хүснэгт 10. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/сая төгрөгөөр/	
				Зөрүү	Биелэлт
1	Тэтгэврийн даатгалын сан	125,470.4	126,361.2	(890.8)	100.7
2	Тэтгэмжийн даатгалын сан	7,714.1	7,100.6	613.5	92.0
3	ҮОМШЕ-ийн даатгалын сан	4,442.3	4,277.8	164.5	96.3
4	Ажилгүйдлийн даатгалын сан	1,840.5	2,142.3	(301.8)	116.4
5	Эрүүл мэндийн даатгалын сан	-	-	-	-
6	Үйл ажиллагааны зардалд зарцуулсан	683.1	679.7	3.4	99.5
7	Хөрөнгө оруулалт	-	-	-	-
8	НДШ-н 50 хувийн буцаалт	-	-	-	-
<b>НИЙТ ДҮН</b>		<b>140,150.4</b>	<b>140,561.6</b>	<b>(411.2)</b>	<b>100.29</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Засаг даргын нөөц хөрөнгөөс 59.5 сая төгрөг, тэмцээн уралдааны шагналын 1.0 сая төгрөг нийт 60.5 сая төгрөгийн орлого нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрчээ.

Үүнээс урамшууллын зардалд 52.2 сая төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлд 7.3 сая төгрөг, тээвэр шатахууны зардалд 1.0 сая төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант онд Нийгмийн даатгалын хэлтэст хэрэгжсэн төсөл хөтөлбөр байхгүй байна.